# САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ӨДӨР ТУТМЫН МЭДЭЭ

**2020.03.10**

*ТА **ИНТЕРНЕТ БАНК** БОЛОН **319708, 319709** УТСААР ХОЛБОГДОН ВАЛЮТЫН ХАНШ ТОХИРОХ БОЛОМЖТОЙ.*

| Валют | Ханш | 24H Chg |
|---|---|---|
| EUR/USD | 1.138 | -0.61% |
| USD/CNY | 6.9459 | -0.47% |
| USD/RUB | 68.5661 | 0.02% |
| USD/JPY | 103.43 | 1.05% |
| USD/KRW | 1197.25 | -0.59% |
| USD/CHF | 0.9315 | 1.38% |
| AUD/USD | 0.6591 | 0.00% |
| GBP/USD | 1.3055 | 0.00% |
| **Индекс** | **Нэгж** | **24H Chg** |
| Dow Jones | 23851.0 | -7.79% |
| S&P 500 | 2746.6 | -7.60% |
| NASDAQ | 7950.7 | -7.29% |
| FTSE 100 | 5965.8 | -7.69% |
| Nikkei 225 | 18972.3 | -3.69% |
| DAX | 10625.0 | -7.94% |
| Hang Seng | 25040.5 | -4.23% |
| SHCOMP | 2943.3 | -3.01% |
| **Метал** | **Ханш (USD)** | **24H Chg** |
| Алт | 1664.64 | -0.94% |
| Мөнгө | 16.9259 | -0.53% |
| Нүүрс (Чин хуанг дао/юань) | 566 | -0.70% |
| Хүрэн нүүрс (БНХАУ) | 33.3 | -0.09% |
| Зэс (LME) | 5535 | -1.28% |
| Төмрийн хүдэр | 631.5 | -4.03% |
| Газрын тос (NYME) | 32.71 | 5.08% |
| **Бонд** | **Хүү** | **24H Chg** |
| US 1M LIBOR | 0.86% | -14.18% |
| US 3M LIBOR | 0.90% | -10.30% |
| US 6M LIBOR | 0.88% | -9.72% |
| US 12M LIBOR | 0.85% | -10.44% |
| US Treasury 10Y | 0.69% | 28.17% |
| UK Treasury 10Y | 0.16% | -32.63% |
| GE Treasury 10Y | -0.86% | -20.56% |
| JP Treasury 10Y | -0.09% | 42.94% |

| Бонд (Монгол) | Хүү | Дуусах огноо | Өгөөж | 24H Chg |
|---|---|---|---|---|
| Гэрэгэ | 5.63% | 5/1/2023 | 6.35% | 0.11% |
| Мазаалай | 10.8% | 4/6/2021 | 5.85% | 0.16% |
| Хуралдай | 8.75% | 3/9/2024 | 6.49% | -0.15% |
| Чингис | 5.13% | 12/05/2022 | 6.11% | -0.05% |
| ХХБ 2020 | 9.38% | 5/19/2020 | 5.72% | -0.01% |
| Самурай | 5.75% | 12/25/2023 | 0.51% | 0.00% |
| МУХБ 2023 | 7.25% | 10/23/2023 | 5.60% | -0.34% |
| МИК 2022 | 9.75% | 1/29/2022 | 12.26% | -1.49% |

## Онцлох мэдээ

- Коронавирусын хурдацтай тархалтын талаарх айдас, түүний эдийн засагт үзүүлж буй нөлөө Даваа гарагийн газрын тосны үнийн уналтаас болж улам гүнзгийрэн улмаар S&P 500-ийн зах зээлийн үнэлгээнээс 5 их наяд ам.долларыг үгүй хийлээ.
- Европын хамгийн их халдвар тархаж, хүний амь үрэгдээд байгаа 60 орчим сая хүн амтай Итали улсын ЗГ-аас тус улсыг бүхэлд нь тусгаарлалтанд орууллаа.
- БНХАУ-ын үйлдвэрлэгчийн үнийн индекс (PPI) 2-р сард 0.4% унаж, хэрэглээний үнийн индекс 5.2% өссөн албан тоон мэдээ гарлаа.

## Валютын зах зээл

АНУ-ын засгийн газрын бондуудын өгөөж бага зэрэг өсөж АНУ-ыг эдийн засгаа дэмжих хөтөлбөр хэрэгжүүлнэ гэсэн найдлага ам.долларын ханшийг иен, евро, франкийн эсрэг эргэн чангарахад нөлөөлжээ. АНУ-ын сангийн сайд С.Мнучин банкны удирдлагуудтай уулзаж томуугийн вирусийн тархалтаас үүссэн цохилтыг зөөлрүүлэхийн тулд илүү олон арга хэмжээ хэрэгжүүлэхээр бэлтгэж байна.

Даваа гарагт сүүлийн нэг жил гаран хугацааны дээд цэгт хүрсэн еврогийн ханш ам.долларын эсрэг 0.24 хувиар сулран 1.14 нэгжид доош сэтэллээ. 3 хоног дараалан хүчтэй чангарсан Швейцарь франкийн ханш 0.36 хувиар суларч 0.9283 нэгжид хүрлээ. Харин фунтын ханш 0.39 хувиар унаж 1.3075 нэгж дээр очлоо.

## Алтны зах зээл

Даваа гарагт коронавирусын дэгдэлт болон түүхий нефть, үнэт цаасны зах зээлийн хөдөлгөөнөөс шалтгаалж хөрөнгө оруулагчид илүү аюулгүй хөрөнгийг сонгосноор 2012 оноос хойш анх удаа алтны үнэ нэг унц нь 1,700 ам.долларт хүрсэн байна. Хөрөнгө оруулагчид коронавирусын эдийн засгийн нөлөөллийг багасгах үүднээс бондын зах зээлийг сонирхож эхэлсэн бол Саудын Араб улс албан ёсны борлуулалтын үнээ бууруулсаны дараа түүхий нефтийн үнэ 20% уналаа. Импорт буурсантай холбогдуулан Хятадын экспорт оны эхний хоёр сард огцом буурчээ.

## Зэсийн зах зээл

Газрын тосны үнийн уналтыг дагаад зэсийн үнэ унаж 3 гаран жилийн доод түвшинд хүрсэн, гэхдээ хөрөнгө оруулагчид БНХАУ-с томоохон дэмжих бодлогууд хэрэгжүүлнэ гэдэгт найдаж доод цэгээс буцжээ. Эрчим хүч бол уул уурхайн зардлын гол хэсэг бөгөөд бага газрын тосны үнэ нь металлын үнийг унагаж байгаа юм. Лондонгийн Металлын Бирж дээр өчигдөр 1 тонн зэсийн үнэ 3.1% хүртэл унаж 2016 оны 12-р сараас хойших доод түвшин болох 5,433 ам.долларт хүрээд эргэн өссөнөөр эцсийн арилжаагаар 1.3% бууран 5,535 ам.долларт хаагджээ.

| Хувьцаа | Ханш | 24H Chg |
|---|---|---|
| Turquoise Hill Resources | 0.4517 | -9.21% |
| Mongolian Mining Corp | 0.375 | -2.60% |
| Mongolian Energy Corp | 0.22 | -4.35% |
| Centerra Gold | 8.77 | -4.67% |

| Макро эдийн засаг (Монгол) | Огноо | Дүн |
|---|---|---|
| Инфляцийн түвшин | 2020 (I) | 5.6% |
| Бодлогын хүү | 2020 (I) | 11.0% |
| Банк хооронын зах зээлийн хүү | 2020 (I) | 10.9% |
| Хадгаламжийн дундаж хүү (төг) | 2020 (I) | 11.4% |
| Хадгаламжийн дундаж хүү (валют) | 2020 (I) | 4.7% |
| Зээлийн дундаж хүү (төг) | 2020 (I) | 16.6% |
| Зээлийн дундаж хүү (валют) | 2020 (I) | 10.3% |

**Ханшийн таамаглал**

| Валют | Q1 20 | Q2 20 | Q3 20 | Q4 20 | 2021 |
|---|---|---|---|---|---|
| EUR/USD | 1.12 | 1.13 | 1.14 | 1.15 | 1.18 |
| GBP/USD | 1.32 | 1.32 | 1.33 | 1.35 | 1.4 |
| USD/CNY | 7.03 | 7.05 | 7.09 | 7.1 | 7.22 |
| USD/JPY | 108 | 108 | 107 | 106 | 109 |
| USD/RUB | 64 | 64 | 64.25 | 64 | 65.94 |
| **Түүхий эд** | | | | | |
| Алт | 1518 | 1528 | 1538 | 1544 | 1561 |
| Зэс | 6218 | 6230 | 6238 | 6200 | 6265 |
| Нүүрс | 62.25 | 59.75 | 60 | 60 | 59.94 |

*эх сурвалж: Блүмбэрг*

**Эдийн засгийн голлох тоо мэдээ**

| Өмнөх өдрийн үр дүн | | Үр дүн | Таам. | Өмнөх |
|---|---|---|---|---|
| JP | Current Account NSA JPY | 612.3B | 626.1B | 524.0B |
| JP | GDP Rev QQ Annualised | -7.10% | -6.60% | -6.30% |
| JP | GDP Revised QQ | -1.80% | -1.70% | -1.60% |
| JP | GDP Cap Ex Rev QQ | -4.60% | -4.30% | -3.70% |
| GE | Industrial Output MM | 3.00% | 1.70% | -3.50% |
| **Өнөөдөр хүлээгдэж буй мэдээ** | | **Цаг** | **Таам.** | **Өмнөх** |
| FR | Industrial Output MM | 15:45 | 2.00% | -2.80% |
| IT | Industrial Output MM SA | 17:00 | 1.80% | -2.70% |
| **Маргааш хүлээгдэж буй мэдээ** | | **Цаг** | **Таам.** | **Өмнөх** |
| UK | GDP Est 3M/3M | 17:30 | 0.10% | 0.00% |
| UK | GDP Estimate MM | 17:30 | 0.20% | 0.30% |
| UK | GDP Estimate YY | 17:30 | 0.90% | 1.20% |
| UK | Manufacturing Output MM | 17:30 | 0.20% | 0.30% |
| US | CPI MM, SA | 20:30 | 0.00% | 0.10% |

Дэлхийн хамгийн том зэс олборлогч Codelco-ийн үйлдвэрлэлийн гарц 1-р сард 6.8% унаж 118,600 тонн болсон бол хамгийн том зэсийн уурхай BHP-ийн Эскондидагийн олборлолт 10% өсөж 100,900 тоннд хүрэв.

## Газрын тосны зах зээл

Өнөөдөр газрын тосны үнэ 6% өсөж Саудын Араб болон ОХУ хоорондын үнийн дайнаас бий болсон 1991 оны Персийн булангийн дайнаас хойших хамгийн том нэг өдрийн уналт удаан үргэлжлэхгүй байх гэсэн найдвар төрүүлээд байна. Өглөөний байдлаар Брент 2.31 ам.доллар (6.7%)-аар өсөж баррел нь 36.67 ам.долларт, WTI 1.79 ам.доллар (5.8%)-аар өсөж баррел нь 32.92 ам.долларт арилжаалагджээ.

OPEC-с бүх бололцоогоороо газрын тосны нийлүүлэлтийг нэмэгдүүлнэ гэсэн шийдвэрийн дараа газрын тосны үнэ унасан бөгөөд улмаар АНУ-ын занар боловсруулагчид зарцуулалтаа улам танаж цаашид гарцаа бууруулахаар яаравчилж эхэллээ.

## Бондын зах зээл

Гадны хөрөнгө оруулалтын сангуудын Азийн хөгжиж буй зах зээлд худалдсан бонд өндөр дүнтэй байлаа. Тодруулбал, Блүүмбергийн цуглуулсан мэдээллээр гадны сангууд 3-р сарын 6-нд цэвэр дүнгээр 157.6 сая ам.долларын Өмнөд Солонгос улсад бүртгэлтэй бондуудаас худалдсан бол 5-нд цэвэр дүнгээр 76.6 сая ам.долларын Энэтхэг улсын бондуудын гарах их байлаа.

## Хөрөнгийн зах зээл

Даваа гарагт Уолл Стрийт 2008 оны санхүүгийн хямралаас хойш нөг өдрийн хамгийн том уналтаа харуулсан ба газрын тосны үнийн бууралт болон коронавирусын эмзэг байдал үргэлжилж байгаа нь АНУ-ын хөрөнгийн зах зээл дээр хөдөлгөөн үүсгэсэн юм. 1991 оны Персийн булангийн дайнаас хойших түүхий нефтийн үнэ хамгийн их уналттай байлаа. Амралтын өдрүүдээр Саудын Араб болон ОХУлс хооронд газрын тос нийлүүлэх гэрээ тохиролцоонд хүрч чадаагүй ба коронавирусын нөлөөллөөс шалтгаалан эрэлт буурсан энэ үед олборлолтын хэмжээгээ нэмэгдүүлэх шийдвэр гаргасан юм. Голлох индексүүд буурч: Dow 7.74%, S&P 7.59%, Nasdaq 7.29%.

***Мэдэгдэл***

*Энэхүү мэдээлэл нь ХХБ-ны нэрийн өмнөөс тус банкны харилцагчдад мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн бөгөөд аливаа нэг гадаад валют, санхүүгийн хэрэгсэл худалдах, худалдан авах болон хөрөнгө оруулалтийг санал болгоогүй болно. Мөн энэхүү мэдээлэл нь аль нэгэн харилцагчийн хөрөнгө оруулалтанд, санхүүгийн байдал болон тусгайлсан эрэлт, хэрэгцээнд тулгуурлаагүй бөгөөд ХХБ нь энэхүү мэдээллийн үнэн зөв болон бодит байдалд ямарваа нэгэн баталгаа гаргахгүй ба мэдээллийг ашигласнаас үүдэн бий болох аливаа алдагдал, сөрөг үр дагаварт хариуцлага хүлээхгүй болохыг мэдэгдэж байна. Энэхүү мэдээлэл нь зохиогчын эрх бүхий мэдээллүүдийг агуулж буй тул зөвшөөрөлгүйгээр хуулбарлах, хэвлэх, гуравдагч этгээдэд түгээхийг хатуу хориглоно. Хэрэв энэхүү мэдээллийг цаашид хүлээн авахаа зогсоохыг хүсвэл гарчиг хэсэгт "UNSUBSCRIBE" гэж бичин уг и-мейлд хариу илгээнэ үү.*